

## **§ Нэг. Баянхонгор аймагт 2017 онд эрх шилжиж ирсэн хөрөнгө**

### **оруулалтын ажлуудын танилцуулга**

#### **А.Засгийн газрын хэрэг эрхлэх газар**

##### **1. Эрдэнэцогт, Шинэжинст, Богд сумдын ЗДТГ-т автомашин нийлүүлэх**

Засгийн газрын хэрэг эрхлэх газраас дээрх сумдад автомашин худалдан авах зардалд тус бүр 35,0 сая, нийт 105,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн ба орон нутгийн төсвийн хөрөнгөөс автомашин худалдан авахад сум тус бүрт 15,0 сая, нийт 45,0 сая төгрөг олгох шийдвэр гарсаны дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газар худалдан авах ажиллагааг 2017 оны 12 дугаар сард зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааг харьцуулалтын арга ашиглан зарлахад шаардлага хангасан үнийн санал ирүүлсэн аж ахуйн нэгж байхгүй тул шууд гэрээ байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэний дагуу “Хашгоёо”, “Өгөөмөр орд”, “Баянхонгор төмөрт” ХХК-иудтай гэрээ байгуулж, гэрээнд заасан хугацаанд автомашиныг хүлээн авч, орлогод бүртгэсэн байна.

Аудитаар Шинэжинст сумын ЗДТГ-т худалдан авсан Land Cruiser 200 маркын автомашин нь Улаанбаатар хотын харьяат иргэн Ц.Батдоржийн нэр дээр, Богд сумын ЗДТГ-т худалдан авсан Land Cruiser 100 маркын автомашин нь Баянхонгор аймгийн харьяат “Баянхонгор төмөрт” ХХК-ийн нэр дээр, Эрдэнэцогт сумын ЗДТГ-т худалдан авсан Land Cruiser 200 маркын автомашин нь Улаанбаатар хотын харьяат иргэн Э.Баярмагнайн нэр дээр эзэшилтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул автомашиныг төсөвт байгууллагын нэр дээр болгох албан шаардлагыг байгууллагуудад хүргүүлэв.

#### **Б. Эрчим хүчний яам**

##### **1. Баянхонгор сумын 4.5 дугаар багийн хүчдэлийн уналттай болон шинэ сууршлийн бүсийн цахилгаан хангамж**

Тус ажилд 290,0 сая төгрөгийн төсөв батлагдсан ба Эрчим хүчний сайдын 2017.09.07-ний өдрийн 120 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад эрхийг

шилжүүлсний дагуу 2017 оны 05 дугаар сард аймгийн ОНӨГ-аас явуулсан нээлттэй тендерт 7 компани оролцсоноос “Хустайн шил” ХХК 254,7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарчээ. Тус арга хэмжээнд аймгийн ОНХС-аас 190,0 сая төгрөгийг олгосон, аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн боловч санхүүжилтийн эрх шилжиж ирээгүй ба 2017.11.14-ний өдөр тус ажлыг улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

Тендер 2017 оны 05 дугаар сард явуулсан байхад 09 дүгээр сард Эрчим хүчний яамнаас эрх шилжсэн талаар аймгийн ОНӨГ, ХОХБТХ-ээс тодруулахад тайлбар ирүүлээгүй болно.

## **В. Эрүүл мэндийн яам**

Эрүүл мэндийн яамнаас Баянхонгор аймгийн Засаг даргад он дамжин хэрэгжиж буй 2225,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 барилга, тухайн онд шилжиж ирсэн 296,0 сая төгрөгийн 3 засварын ажил, 10,8 сая төгрөгийн мотоцикл худалдан авах ажлууд хэрэгжсэн байна.

### **1. Сумын эрүүл мэндийн төвийн барилга 10 ор /Баянхонгор, Баянбулаг сум/**

Баянбулаг сумын эрүүл мэндийн төвийн барилга 2014 оны төсөвт 600,0 сая төгрөгөөр батлагдаж, тендерийг Улаанбаатар хотын худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж “Хорол багана констракшн” ХХК-тай 585.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ба гэрээнд барилгыг 14x18м-ийн хэмжээтэй, зоорьгүй, 2 давхар барилга байхаар тусгасан байдаг. Гэтэл 2015 оны Төсвийн тухай хуульд төсөвт өртөг нэмэгдэн, өмнөх онд хийгдэх барилгын хэмжээг өөрчилж 13,9 x 32м-ийн хэмжээтэй, зоорьгүй, нэг давхар барилгыг “Хангайн нар” ХХК-ийн ХН 13/18 шифр бүхий зургаар, 1112,7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр ЭМСЯ-ны төрийн нарийн бичгийн даргатай гэрээг өөрчлөн байгуулжээ.

2017 оны Төсвийн тухай хуулиар 250,0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдаж, аймгийн Төрийн сангийн дансаар 249,8 сая төгрөгийн санхүүжилт ирснээс 191,3 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгож, Хөрөнгө оруулалтын техник хяналтын барьцаа дансанд 58,5 сая төгрөгийг байршуулсан байна.

Тус ажлыг 2017.03.10-ний өдөр улсын комисст хүлээлгэж өгч, орлогод бүрэн авсан ба ашиглалтын явцад нам даралтын зуух галлагааны үед бууддаг, тогоо нь цоорсон, барилгын агааржуулалтыг дагаж цан цохидог, нар тусдаггүй өрөөнд цан ихээр цохисноос мөөгөнцөр үүссэн, төрөх өрөөний ойролцоо бохирын цооног байршуулсан нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй, мөн бохирын хоолой дотор байршуулсан халаах утас шатсанаас бохирын хоолой ашиглалтгүй болсон, холбооны шугам холболт хийгээгүйн улмаас ашиглах боломжгүй болсон зэрэг зөрчил аудитаар илэрсэн тул Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.19-т заасан “Барилгын чанарын баталгаат хугацаа Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийг баримтлах бөгөөд баталгаат хугацаа нь байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид эвдрэл гэмтэл гарвал гүйцэтгэгч байгууллага захиалагчийн шаардлагаар үнэ төлбөргүй засварлана” гэснийг үндэслэн “Хорол багана констракшн” ХХК-аар зөрчлийг арилгуулах албан шаардлагыг тус журмын 5.4-т заасан “Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг ..., барилгын чанарт тавих хяналтыг төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэж заасны дагуу аймгийн Засаг даргад хүргүүлэв.

## **2. Сумын эрүүл мэндийн төвийн барилга 10 ор /Баянхонгор, Шаргалжуут тосгон/**

Шаргалжуут тосгоны 10 ортой Эрүүл мэндийн төвийн барилга анх 2014 оны Төсвийн тухай хуулиар 580,0 сая төгрөгөөр, 2015 онд 1112.7 сая төгрөгөөр тус тус батлагдсанаас 2017 онд Төсвийн тухай хуулиар санхүүжилтийн үлдэгдэл 300,0 сая төгрөгийг олгохоор батлагдсаны дагуу аймгийн Төрийн сангийн дансаар 300,0 сая төгрөгийн санхүүжилт ирснээс 236,2 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгож, Хөрөнгө оруулалтын техник хяналтын барьцаа дансанд 63,8 сая төгрөгийг байршуулсан байна.

Тус ажлыг гүйцэтгэгч “Алтайн газрын хүч” ХХК 2017.10.04-ний өдөр улсын комисст ажлыг хүлээлгэн өгснийг ашиглагч байгууллага хөрөнгөд орлогод авч, хөрөнгийн чанар сайн, ашиглалт хэвийн байна.

## **3. Эмнэлгийн их засвар /Баянхонгор, Гурванбулаг сум/**

Тус арга хэмжээнд 90,0 сая төгрөг батлагдаж, Эрүүл мэндийн сайдын 2017.05.17-ний өдрийн А/205 тушаалаар аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсний дагуу аймгийн ОНӨГ нээлттэй тендер зарлаж, тендерт “Баян товгор” хоршоо 88,7 сая төгрөгөөр шалгарч 2017.07.06-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Аймгийн Төрийн сангийн дансаар дамжин санхүүжүүлсэн 88,7 сая төгрөгийг гүйцэтгэгчид бүрэн олгож, 2017.08.30-нд улсын комисст бүрэн хүлээлгэж өгсөн ба хөрөнгийг орлогод авчээ.

Ашиглалтын явцад үндсэн барилга, өргөтгөл хоёрын залгаагаар дулаан алддагаас шалтгаалж өргөтгөл хийсэн өрөөнүүд хүйтэн, ус зайлуулах хоолой хийгээгүйгээс өргөтгөлийн залгаа руу ус орж цан цохидог зөрчил аудитаар илэрсэн тул Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.19 дэх заалтыг үндэслэн “Баян товгор” хоршоогоор зөрчлийг арилгуулах албан шаардлагыг тус журмын 5.4-т заасны дагуу аймгийн Засаг даргад хүргүүлэв.

#### **4. Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар ажлын дутуу санхүүжилт /Баянхонгор аймаг, Галуут сум/**

Тус арга хэмжээнд 127,9 сая төгрөг батлагдаж, Эрүүл мэндийн сайдын 2017.01.23-ний өдрийн А/35 тушаалаар аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсний дагуу аймгийн ОНӨГ нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгчээр “Нүнжигт инженеринг” ХХК 127,9 сая төгрөгөөр шалгарч 2017.07.25-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Аймгийн Төрийн сангийн дансаар дамжин санхүүжүүлсэн 127,9 сая төгрөгийг гүйцэтгэгчид бүрэн олгож, 2017.10.04-нд улсын комисст бүрэн хүлээлгэж өгч, хөрөнгийг орлогод авсан ба чанар, ашиглалтын байдал хэвийн байна.

#### **5. Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн эмнэлгийн дотоод засварын ажил**

Тус арга хэмжээнд улсын төсвөөс 78,0 сая төгрөг батлагдаж, Эрүүл мэндийн сайдын 2017.11.20-ний өдрийн А/428 тоот тушаалаар Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын даргад эрх шилжиж ирсний дагуу аймгийн ОНӨГ–аас харьцуулалтын аргыг ашиглан тендер зарлаж, 71,7 сая төгрөгөөр “Базар дарь” ХХК шалгарч, 2017.12.13-ний өдөр гэрээ байгуулсан байна.

Эрүүл мэндийн яамнаас аймгийн Төрийн сангийн дансаар 70,7 сая төгрөгийн эрх нээгдэж, 43,0 сая төгрөгийг гүйцэтгэгчид, 27,7 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын техник хяналтын барьцаа дансанд байршуулжээ.

Тус арга хэмжээний гэрээнд санхүүжилтийг 60:20:20 харьцаагаар олгохыг зааж, анхны гэрээнд тус ажлыг 2018.02.01-ний өдөр ашиглалтанд хүлээлгэж өгөхөөр заасан боловч барилгын халаалтын байдлаас шалтгаалж, ажил гүйцэтгэх боломжгүйгээс нэмэлт гэрээг 2018.03.10-ны өдөр байгуулсан байна.

Санхүүжилтийн 60 хувийг олгосон байхад аудитаар засварын буулгах ажил хийгдэж, дотор заслын ажил эхлэх шатандаа байгаа тул ажлыг чанартай гүйцэтгэж, гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

## **6. Сумдын Эрүүл мэндийн төвд мотоцикл нийлүүлэх**

Эрүүл мэндийн сайдын 2017.11.20-ний өдрийн А/452 тоот тушаалаар 5 суманд 6 ширхэг мотоциклийн үнэнд 10,8 сая төгрөг батлагдаж, аймгийн ЭМГ-ын даргад эрх шилжүүлсний дагуу аймгийн ОНӨГ-аас зарласан тендерт “Хос соронз” ХХК шалгарч 10,6 сая төгрөгөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулжээ.

Баацагаан суманд 2 ширхэг, Заг, Жинст, Богд, Жаргалант сумдад тус бүр 1 ширхэг, нийт 6 ширхэг мотоциклийг нэг бүрийг нь 1,7 сая төгрөгөөр нийлүүлж, ашиглагч байгууллагууд хөрөнгөд орлогод авсан байна.

Аймгийн Төрийн сангийн дансаар 10,6 сая төгрөгийн санхүүжилт ирснээс гүйцэтгэгчид 8,5 сая төгрөгийг олгож, хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 2,1 сая төгрөгийг байршуулсан байна.

Аудитаар тухайн хөрөнгийг хүлээлцсэн акт байхгүй, хөрөнгийг эзэмшигчийн гэрчилгээг гаргуулаагүй зөрчилд зөрчлийг арилгуулах албан шаардлага өглөө.

## **Г. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам**

БСШУС-ын яамнаас Баянхонгор аймгийн Засаг даргад он дамжин хэрэгжиж буй 1157.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 барилга, тухайн онд эрх шилжиж ирсэн 951.2 сая төгрөгийн 7 засварын ажлууд хэрэгжсэн байна.

### **1. Баянговь сумын соёлын төв**

Баянговь сумын Соёлын төвийн барилгын ажлыг “Эй Ар Би Си” ХХК 938.6 сая төгрөгөөр 2014.12.15 өдөр дуусгахаар гэрээ байгуулсан боловч анхны тендер зарласан төсөвт зарим ажил суугдаагүй, түгээмэл тархацтай ашигт матлтмалыг тусгай хамгаалалттай газраас татахаар тооцоолсон зэрэг ТЭЗҮ алдаатай гэх шалтгаанаар 2015 онд төсөв өөрчлөгдөж 1157.0 сая төгрөг болон нэмэгдэж 2017 онд үлдэгдэл санхүүжилтийн 186.9 сая төгрөг батлагдаж төрийн сангийн дансаар эрх нээгдэж ирсэн ба 130.8 сая төгрөгийг гүйцэтгэгчид олгож, Хөрөнгө оруулалтын техник хяналтын барьцаа дансанд 56.1 сая төгрөгийг барилга байгууламжийн баталгаанд байршуулсан байна.

Тус барилгыг 2017.12.01-нд улсын комиссоор хүлээн авсан гэх боловч аудитаар очиж үзэхэд зарим өрөөнд болон шатны хэсэгт плита хийгдээгүй, дотор заслын ажил дутуу хийгдсэн, дотор цахилгааны ажил бүрэн хийгдэж дуусаагүй, гадна тохижилтын ажил дутуу хийгдсэн байдалтай байна. Иймд тус ажлыг комиссоор хүлээн авч гүйцэтгэлд гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцож, дутуу ажлыг гүйцээх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

## **2. Сургуулийн барилгын дээврийн засвар /Баянхонгор, Баян-Өндөр сум/**

Тус арга хэмжээнд 87,5 сая төгрөг батлагдаж, БСШУС-ын сайдын 2017.05.08-ны өдрийн 1а/3658 тоот тушаалаар аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсний дагуу аймгийн ОНӨГ нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгчээр “Хорго групп” ХХК 79,8 сая төгрөгөөр шалгарч 2017.06.30-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Аймгийн Төрийн сангийн дансаар дамжин санхүүжүүлсэн 78.4 сая төгрөгийг гүйцэтгэгчид бүрэн олгож, техник хяналтын зардлын 1.5 сая төгрөгийг сангийн яаманд авч үлдсэн байна. 2017.09.04-нд улсын комисст бүрэн хүлээлгэж өгч, хөрөнгийг орлогод авсан ба чанар, ашиглалтын байдлыг аудитаар очиж шалгахад дээврийг ханатай чацуулан хийсэн байсныг захиалагчийн хяналтаар очиж шаардлага тавьсаны дагуу шаардлагад нийцүүлэн бэхэлгээ хийж уртасгасан боловч шуурганд зарим хэсгээр хуурсан байгаа тул зөрчлийн арилгуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

## **3. Сургуулийн барилгын засвар /Баянхонгор, Эрдэнэцогт сум/**

БСШУС-ын сайдын 2017.03.13-ны өдрийн А/82 тоот тушаалаар аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсний дагуу 140.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий засварын

ажлыг аймгийн ОНӨГ нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгчээр “Базардарь” ХХК 138.4 сая төгрөгөөр шалгарч 2017.06.23-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Аймгийн Төрийн сангийн дансаар дамжин санхүүжүүлсэн 138.4 сая төгрөгийг гүйцэтгэгчид бүрэн олгож, 2017.08.26-нд улсын комисст бүрэн хүлээлгэж өгч, хөрөнгийг орлогод авсан ба чанар, ашиглалтын байдлыг аудитаар очиж шалгахад үүдний довжооны хэсгийн плита хагарсан, гадна пасадын хэсэг зарим хэсгээр хагарсан, технологийн ангид цонх цантаж, чийг их үүссэнээс мөөгөнцөрдөж, муухай үнэр гарч байгаагаас хичээллэх нөхцөлгүй, дотор зарим гэрэлтүүлэг шатсан, дотор таазны эмульс зарим хэсгээр хуурсан байгаа тул зөрчлийн арилгуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

#### **4. Сургуулийн халаалтын засвар/Баянхонгор, Галуут сум/**

Тус арга хэмжээнд 50.8 сая төгрөг батлагдаж, БСШУС-ын сайдын 2017.05.08-ны өдрийн 1а/3658 тоот тушаалаар аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсний дагуу аймгийн ОНӨГ харьцуулалтын аргаар тендер зарлаж, гүйцэтгэгчээр “Базардарь” ХХК 50.8 сая төгрөгөөр шалгарч 2017.06.15-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Техник хяналтын зардлын 0.8 сая төгрөгийг сангийн яам авч үлдсэн бөгөөд аймгийн Төрийн сангийн дансаар дамжин санхүүжүүлсэн 50.0 сая төгрөгийг гүйцэтгэгчид бүрэн олгож, 2017.07.18-нд улсын комисст бүрэн хүлээлгэж өгч, хөрөнгийг орлогод авсан ба аудитаар очиж шалгахад чанар, ашиглалтын байдал хэвийн байна.

#### **5. Хачин ламын сүмийг сэргээн засварлах ажил /Баянхонгор, Эрдэнэцогт сум/**

БСШУС-ын сайдын 2017.05.08-ны өдрийн 1а/3658 тоот тушаалаар аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсний дагуу 375.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр аймгийн ОНӨГ нээлттэй тендер шалгаруулалтын аргаар тендер зарлаж, гүйцэтгэгчээр "Жамьян пайтан" ХХК 373.5 сая төгрөгөөр шалгарч 2017.08.21-ний өдөр гэрээ байгуулсан байна.

Аймгийн Төрийн сангийн дансаар дамжин санхүүжүүлсэн 373.5 сая төгрөгийг гүйцэтгэгчид бүрэн олгож, 2017.12.01-нд улсын комисст бүрэн хүлээлгэн өгсөн гэх

боловч аудитаар очиж шалгахад гадна тохижилт, хайс хашааны ажил хийгдээгүй, камержуулалтын сервэр ирээгүй, тус гандангийн зүгээс хэрэгжилтийн явцыг 90 хувьтай гэж үзэж байна. Иймд тус ажлыг комиссоор хүлээн авч гүйцэтгэлд гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцож, дутуу ажлыг гүйцээх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Мэргэжлийн эрх бүхий шинжээчээр тухайн ажлын гүйцэтгэлийг санхүүжилтийн гүйцэтгэлтэй тулган баталгаажуулах шаардлагатай.

#### **6. Байгалийн түүхийн музейн барилгын дээвэр, халаалтын засвар**

БСШУСС-ын 2017.03.28-ний өдрийн А/99 тоот тушаалаар Байгалийн түүхийн музейн барилгын дээвэр, халаалтын засварын ажилд батлагдсан 70,5 сая төгрөгийн ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, тайлагнах эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсний дагуу аймгийн ОНӨГ-аас харьцуулалтын аргаар тендер зохион байгуулсан байна.

Харьцуулалтын аргаар зарласан тендер шалгаруулалтад “Навтгархайрхан” ХХК, “БДЗ” ХХК, “Эх бүрдэн” ХХК зэрэг компани оролцсоноос “Эх бүрдэн” ХХК шалгарсан боловч “БДЗ” ХХК Сангийн яаманд гомдол гаргажээ. Сангийн яамнаас гомдлыг хянаж, тендерийг дахин зарлах албан бичиг ирүүлсний дагуу дахин тендер зарлахад “Эх бүрдэн” ХХК-аас өөр компани ирээгүй тул аймгийн Засаг дарга 2017.07.05-ний өдөр тус компанитай 68,9 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулжээ.

Аймгийн төрийн сангийн дансаар 68,9 сая төгрөгийн санхүүжилт орсныг “Эх бүрдэн” ХХК-д бүрэн олгож, 2017.08.15-ний өдөр засварын ажлыг улсын комисст хүлээлгэн өгснийг аймгийн Түүх угсаатны зүй - Байгалийн музей тус ажлыг орлогод бүртгэсэн байна. Аудитаар шалгахад чанар, ашиглалт хэвийн байсан ба засварын ажилд санал гомдолгүй гэсэн албан бичгийг ашиглагч байгууллагаас ирүүлсэн байна.

#### **7. Түүх, угсаатны зүйн музейн барилгын дээвэр, халаалтын засвар**

Түүх угсаатны зүй - Байгалийн музейн барилгын дээвэр, халаалтын засварын ажилд 169,7 сая төгрөг батлагдаж, тус ажлыг зохион байгуулах,

хэрэгжүүлэх, тайлагнах эрхийг аймгийн Засаг даргад БСШУСС-ын 2017.03.28-ний өдрийн А/99 тоот тушаалаар шилжүүлжээ.

Аймгийн ОНӨГ-аас 2017.04.20-ний өдөр үнэлгээний хороо байгуулж, нээлттэй тендер зарлахад 5 компани оролцсоноос “RMB” ХХК шалгарч, аймгийн Засаг даргатай 2017.06.16-ний өдөр 149,3 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, 2017.08.29-ний өдөр улсын комисст хүлээлгэн өгчээ.

Аймгийн төрийн сангийн дансаар 149,3 сая төгрөгийн санхүүжилт ирснийг гүйцэтгэгчид бүрэн олгосон ба аймгийн Түүх, угсаатны зүйн музейд хийсэн засварын ажилд одоогоор санал гомдол байхгүй, хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгажээ.

#### **8. Өлзийт сумын сургуулийн дотуур байрны гадна дулаан, халаалтын шугамын засвар**

Тус арга хэмжээнд 79,6 сая төгрөг батлагдаж, БСШУСС-ын 2017.05.08-ний өдрийн 1а/3658 тоот тушаалаар аймгийн Засаг даргад эрх шилжиж ирсний дагуу аймгийн ОНӨГ-аас тендер зарлаж, гүйцэтгэгчээр “RMB” ХХК 69,0 сая төгрөгөөр шалгарч 2017.06.23-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Аймгийн Төрийн сангийн дансаар дамжин санхүүжүүлсэн 69,0 сая төгрөгийг гүйцэтгэгчид бүрэн олгож, 2017.09.01-нд улсын комисст бүрэн хүлээлгэж өгч, хөрөнгийг орлогод авсан ба чанар, ашиглалтын байдал хэвийн байна.

#### **2016 онд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажилд аудитын явцад гомдол ирснийг шалгасан тухай**

Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны их засварын ажлыг 2016 онд “Элбата” ХХК 48,0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна.

Гурванбулаг сумын сургуулиас 2018.03.09-ний өдөр ирүүлсэн 18 тоот албан бичгийн дагуу газар дээр нь очиж шалгахад хаалганы нугас цоож эвдэрсэн, паркетан шал зарим хэсгээрээ хөндийрсөн, цонхны гадна амалгаа хагарч унаснаас зай завсар их гарсан, дулаан их алддаг зөрчил илрэв. Иймд Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалт, төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.19-т заасан “Барилгын чанарын баталгаат хугацаа Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийг баримтлах бөгөөд баталгаат хугацаа нь байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн

нөлөөнөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид эвдрэл гэмтэл гарвал гүйцэтгэгч байгууллага захиалагчийн шаардлагаар үнэ төлбөргүй засварлана” гэснийг үндэслэн “Элбата” ХХК-аар зөрчлийг арилгуулах албан шаардлагыг тус журмын 5.4-т заасан “Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг ..., барилгын чанарт тавих хяналтыг төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэж заасны дагуу аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэв.

## **§ Хоёр. Аймагт эрх нь шилжиж ирээгүй, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын талаар**

### **1. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга /төгсөгчдийг ажлын байраар хангах бичил Нийтийн ахуйн үйлчилгээний төв/**

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн төгсөгчдийг ажлын байраар хангах, бичил нийтийн аж ахуйн үйлчилгээний төвийн 146.97 м<sup>2</sup> талбай бүхий сэндвичин барилгыг барих арга хэмжээнд 2013 онд 50,0 сая төгрөг батлагдаж, үүнээс 2017 оны Төсвийн тухай хуулиар 19,6 сая төгрөг олгохоор батлагджээ. Аудитаар тус барилгын ашиглалт хэвийн, харин хөрөнгөд 19645.3 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн зөрчилтэй тул хөрөнгөд залруулж бүртгэх албан шаардлага өгөв.

### **2. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/**

“Бридж констракшн” ХХК-ний 2011 оноос хойш улсын төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж, 2017.11.01-ний өдөр 2017/08 тоот актаар улсын комисст хүлээлгэн өгч, тус барилгад “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК 2017.12.28-ний өдрөөс хойш үйл ажиллагаа явуулж байна

Тус барилгын бохирын хоолой хүйтэнд хөлддөг тул ашиглагдахгүй, уурын зуухны яндан нарийн учраас өвөл хүйтэнд цан цохиж бөглөрдөг, барилга дулаан алдалт ихтэй учир дулаалгын ажилд 760,0 мянган төгрөгийг байгууллагаас гаргасан байгаа тул Барилгын тухай хуульд заасны дагуу баталгаат хугацаанд гүйцэтгэгч компанид асуудлыг тавьж шийдвэрлүүлэх зөвлөмжийг ашиглагч байгууллагад өгөв.

### **3. Орон нутгийн боловсрол, эрүүл мэндийн салбарт хийгдсэн сүлжээний тоног төхөөрөмжийн ажил**

“Шинэ зуун боловсрол” төслийн хүрээнд 20 сумын сургуульд 169,7 сая төгрөгийн сүлжээний тоног төхөөрөмж, Богд, Шинэжинст, Эрдэнэцогт сумдад 70,3 сая төгрөгийн утасгүй сүлжээний тоног төхөөрөмж тавих ажлыг “Sharelink” ХХК 2017 оны 6-8 сарын хугацаанд хийж гүйцэтгэжээ. БСШУСС-ын 2017.12.13-ний өдрийн А/362 тоот тушаалаар дээрх тоног төхөөрөмжүүдийг үндсэн хөрөнгөд орлого авчээ.

Тус төслийн хүрээнд хийгдсэн ажилтай хамт “Цахим эрүүл мэнд” төсөл хэрэгжиж, энэ ажлыг хийгдэх үеэр аймгийн эрүүл мэндийн салбарын сумдын бүх эмнэлэг, аймгийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд сүлжээний тоног төхөөрөмж суурилуулсан байна.

Тоног төхөөрөмж суурилуулах ажлыг 2018 оны 5-6 сард гүйцэтгэгч компани ажлыг бүрэн хийж дуусгана, тус ажил бүрэн хийгдээгүй, үнийн дүн зөрүүтэй байгаа тул 2017 онд хөрөнгөд бүртгээгүй гэсэн тайлбарыг аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн ирүүлсэн.

#### **4. Нэгдсэн эмнэлгийн угаалга, ариутгалын барилга /Баянхонгор, Баянхонгор сум/**

Нэгдсэн эмнэлгийн хашаанд баригдаж буй “Ган мөнхжин” ХХК-ийн гүйцэтгэсэн угаалга, ариутгалын барилгыг 2017.12.19-нд хүлээж авсан боловч одоогоор зориулалтын дагуу ашиглаагүй, эмийн сангийн зориулалтаар ашиглаж байгаа ба аудитаар гадна тохижилтийн ажил хийгдээгүй байна.

#### **5. Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Баянхонгор, Шинэжинст сум/**

“Ганмөнхжин” ХХК-ийн гүйцэтгэж буй 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг 2017.12.06-ний өдөр барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах хэсэгчилсэн комиссын 2017/28 тоот дүгнэлтээр ашиглалтад хүлээж авсан боловч аудитаар газар дээр нь очиж шалгахад дээврийн хар цаас хууларч унасан, гадна тохижилт хийгдээгүй, зарим өрөөний сантехникийн ажил дутуу, төсөвт тусгагдсан атмор халаагч суурилагдаагүй зэргээр хэрэгжилт дутуу байдалтай, цэцэрлэгийн барилгыг ашиглаж эхлээгүй байна.

#### **6. Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 14 ор /Баянхонгор, Баянцагаан сум/**

Тус ажлыг 820,0 сая төгрөгөөр “Жам” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд аудитын явцад газар дээр нь очиж шалгахад 2 давхар барилгын карказ цутгагдсан байдалтай байна.

#### **7. Сургуулийн барилга, 960 суудал /Баянхонгор, Баянхонгор сум/**

2012 оноос хойш “Их наяд хөгжил” ХХК –ийн барьж байгаа 960 хүүхдийн сургуулийн барилгын блокуудын ханын өрлөг бүрэн хийгдсэн, дотор заслын ажил хийгдсэн байдалтай орхигдсон байна. Эрх шилжиж ирээгүй тухайн ажлын гүйцэтгэлийг санхүүжилтийн гүйцэтгэлтэй тулган баталгаажуулах шаардлагатай.

#### ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Б.ДОЛЖМАА  
Б.АЗБАЯР

#### ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА  
Б.МӨНХБАТ

Тус ажлыг 820,0 сая төгрөгөөр “Жам” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд аудитын явцад газар дээр нь очиж шалгахад 2 давхар барилгын карказ цутгагдсан байдалтай байна.

**7. Сургуулийн барилга, 960 суудал /Баянхонгор, Баянхонгор сум/**

2012 оноос хойш “Их наяд хөгжил” ХХК –ийн барьж байгаа 960 хүүхдийн сургуулийн барилгын блокуудын ханын өрлөг бүрэн хийгдсэн, дотор заслын ажил хийгдсэн байдалтай орхигдсон байна. Эрх шилжиж ирээгүй тухайн ажлын гүйцэтгэлийг санхүүжилтийн гүйцэтгэлтэй тулган баталгаажуулах шаардлагатай.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Б.ДОЛЖМАА  
Б.АЗБАЯР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.ЦЭЦЭГМАА  
Б.МӨНХБАТ

2017 ОНД ШИНЭЭР ЭХЭЛСЭН БУЮУ ЗУРАГ ТӨСӨВТ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА


Төсвийн ерөнхийлөн захирагч Баянхонгор аймаг

(сая төгрөг)


№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Зураг хийсэн компаний нэр	Төсөвчний нэр	Анхны зураг, төсөв				Зураг, төсөвт оруулсан өөрчлөлт				Тайлбар /Зураг, төсөвт өөрчлөлт хийсэн шалтгаан, бусад тайлбар/			
					Зураг, төсөвт магадлал хийсэн				Шийдвэр гаргагч							
					Зураг, төсөвт магадлал хийсэн	Огноо	Магадлалын ерөнхий дүгнэлтийн дугаар	Баталгаажсан төсөвт өртөг	Захиалагч	Зураг төсвийн компани	Гүйцэтгэгч	Дахин магадлал хийсэн		Огноо	Магадлалын ерөнхий дүгнэлтийн дугаар	Баталгаажсан нийт төсөвт өртөг
6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17					
1	XII.1.2.1.1.78	Сургуулийн халаалтын засвар /Баянхонгор, Галуут сум/	"ЦЭСДА" ЗБН	Ц.Орхонтамир												8. Төсвийг 50.8 сая төгрөгөөр хийсэн ба магадлалын дүгнэлт хийлгээгүй.
2	XVI.2.1-3.3	Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн эмнэлгийн дотоод засварын ажил	"Бумбат буурь" ХХК	Б.Ганбаатар												4. Төсөл арга хэмжээний тендерийг зохион байгуулсан аймгийн ОНӨГ-аас ХАА зохион байгуулах үед засварын ажлын зураг байгаагүй гэсэн тайлбар өгсөн. 8. Төсвийг 70.8 сая төгрөгөөр тооцсон ба магадлалын дүгнэлт хийлгээгүй.
3	X.1.1.2.2	Байгалийн түүхийн музейн барилгын дээвэр, халаалтын засвар /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/	"Бумбат буурь" ХХК	Б.Ганбаатар												8. Төсвийг 70.5 сая төгрөгөөр тооцсон ба магадлалын дүгнэлт хийлгээгүй.
4	X.1.1.2.3	Түүх угсаатны зүйн музейн барилгын дээвэр, халаалтын засвар /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/	"Бумбат буурь" ХХК	Б.Ганбаатар												8. Төсвийг 169.2 сая төгрөгөөр тооцсон ба магадлалын дүгнэлт хийлгээгүй.
5	XVII.1.1	Баянхонгор сумын 4.5 дугаар багийн хүчдэлийн уналттай болон шинэ сууршлын бүсийн цахилгаан хангамж /Баянхонгор/	"Халх сүмбэр" ХХК	Б.Түвшинбаяр												8. Төсвийг 290.0 сая төгрөгөөр тооцсон ба магадлалын дүгнэлт хийлгээгүй.
6	XII.1.2.1.1.79	Сургуулийн дотуур байрны гадна дулаан, халаалтын шугам /Баянхонгор, Өлзийт сум/	"ЦЭСДА" ЗБН	Ц.Орхонтамир												8. Төсвийг 79.6 сая төгрөгөөр тооцсон ба магадлалын дүгнэлт хийлгээгүй.

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Анхны зураг, төсөв				Зураг, төсөвт оруулсан өөрчлөлт						Тайлбар /Зураг, төсөвт өөрчлөлт хийсэн шалтгаан, бусад тайлбар/			
			Зураг хийсэн компаний нэр	Төсөвчний нэр	Зураг, төсөвт магадлал хийсэн				Шийдвэр гаргагч		Дахин магадлал хийсэн					
					Байгууллагын нэр	Огноо	Магадлалын ерөнхий дүгнэлтийн дугаар	Баталгаажсан төсөвт өртөг	Захиалагч	Зураг төсвийн компани	Гүйцэтгэгч	Байгууллагын нэр		Огноо	Магадлалын ерөнхий дүгнэлтийн дугаар	Баталгаажсан нийт төсөвт өртөг
А	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
7	XII.1.2.1.1.80	Сургуулийн барилгын дээвэр, гадна фасад засвар /Баянхонгор, Баян-Өндөр сум/	"ОСИБ-ЗТ" ХХК	Р.Цэрэнпил, Ц.Мөнх-Эрдэнэ												8. Төсвийг 89.6 сая төгрөгөөр тооцсон ба магадлалын дүгнэлт хийлгээгүй.
8	XII.1.2.1.1.6	Сургуулийн барилгын засвар /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	ЦЭСДА ЗБН	Ц.Орхонтамир	Барилгын хөгжлийн төв	2017.03.16	167/2018	140.2								7. Зураг төсвийг 2017 онд хийж, ажлыг 2017 оны 08 дугаар сард хүлээж авсан байхад магадлалыг 2018 оны 03-р сард хийлгэжээ.
9	XVI.2.1-3.1	Эмнэлгийн их засвар /Баянхонгор, Гурванбулаг сум/	"ЦЭСДА" ЗБН	Ц.Орхонтамир												8. Төсвийг 90.3 сая төгрөгөөр тооцсон ба магадлалын дүгнэлт хийлгээгүй.
10	XVI.2.1-3.2	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар ажлын дутуу санхүүжилт /Баянхонгор аймаг, Галуут сум/	"ЦЭСДА" ЗБН	П.Уянга												8. Төсвийг 128.0 сая төгрөгөөр тооцсон ба магадлалын дүгнэлт хийлгээгүй.
11	X.2.2.1.3	Хачин ламын сүмийг сэргээн засварлах ажил /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	"Сүлд проект" ХХК	Д.Соёлмаа												8. Төсвийг 372.1 сая төгрөгөөр тооцсон ба магадлалын дүгнэлт хийлгээгүй.
		<b>ДҮН</b>						140.2								


СУДАЛГАА ГАРГАСАН: АХЛАХ АУДИТОР  
албан тушаал

  
Б.ДОЛЖМАА  
гарын үсэг Гарын үсгийн тайлал


АУДИТОР  
албан тушаал

  
Б.АЗБАЯР  
гарын үсэг Гарын үсгийн тайлал

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР  
албан тушаал

  
Д.ЦЭЦЭГМАА  
гарын үсэг Гарын үсгийн тайлал

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
албан тушаал

  
Б.МӨНХБАТ  
гарын үсэг Гарын үсгийн тайлал



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА, ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ НЬ 2017 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

Төсвийн ерөнхийлөн захирагч Баянхонгор аймаг

(сая төгрөг)

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Эрх шилжүүлсэн эсэх					ХАА-нд мөрдөгдсөн журам			ХАА-ны хэлбэр		Тендерт зарцуулсан хугацаа					Төсөвт өртөг		Тайлбар		
			Үгүй	Тийм	Эрх шилжүүлэн хүлээн авсан байгууллагын нэр	Эрх шилжүүлсэн		Нээлттэй	Тендер			Үнэлгээний хороо		Тендерийн урилга нийтэлсэн огноо	Гэрээ байгуулах эрх олгосон огноо	Зарцуулсан нийт хугацаа (хоног)	ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан төсөвт өртөг (Хяналтын төсөв)	Шалгарсан төсөвт өртөг	Тендерийн хэмнэлт (+), хэтрэлт (-)			
						Огноо	Дугаар		Хязгаар-лагдмал	Харьцуулалт	Шууд гэрээ	Цаас	Цахим								Огноо	Дугаар
A	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23
1	IV.3.1.1	Эрдэнэцогт сумын ЗДТГазарт автомашин		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.11.24	282			1		1		2017.12.06	A/833	2017.12.06	2017.12.15	9	50.0	50.0	-	18.Харьцуулалтаар зарлаад шаардлага хангасан үнийн санал ирээгүй тул гэрээ шууд байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн.
2	IV.3.1.3	Шинэжинст сумын ЗДТГазарт автомашин		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.11.24	282			1		1		2017.12.06	A/830	2017.12.06	2017.12.15	10	50.0	50.0	-	18.Харьцуулалтаар зарлаад шаардлага хангасан үнийн санал ирээгүй тул гэрээ шууд байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн.
3	IV.3.1.2	Богд сумын ЗДТГазарт автомашин		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.11.24	282			1		1		2017.12.05	A/832	2017.12.05	2017.12.13	8	50.0	50.0	-	18.Харьцуулалтаар зарлаад шаардлага хангасан үнийн санал ирээгүй тул гэрээ шууд байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн.
4	XII.1.2.1.1.6	Сургуулийн барилгын засвар /Баянхонгор,Эрдэнэцогт сум/		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.03.13	A/82	1				1		2017.05.08	A/361	2017.05.12	2017.06.16	39	140.0	138.4	1.62	

A	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23
5	XII.1.2.1.1.78	Сургуулийн халаалтын засвар/Баянхонгор, Галуут сум/		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.05.08	1а/3658			1		1		2017.05.26	A/411	2017.05.29	2017.06.15	20	50.8	50.8	-	18. Тендерт харьцуулалт аргыг ашигласан ба шаардлага хангасан үнийн санал ирээгүй тул гэрээ шууд байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн.
6	XII.1.2.1.1.79	Сургуулийн дотуур байрны гадна дулаан, халаалтын шугам /Баянхонгор, Өлзийт сум/		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.05.08	1а/3658			1		1		2017.05.26	A/407	2017.05.30	2017.06.14	19	79.6	69.0	10.6	
7	XII.1.2.1.1.80	Сургуулийн барилгын дээвэр, гадна фасад засвар /Баянхонгор, Баян-Өндөр сум/		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.05.08	1а/3658	1				1		2017.05.26	A/408	2017.05.26	2017.06.29	33	87.5	79.8	7.7	
8	X.2.2.1.3	Хачин ламын сүмийг сэргээн засварлах ажил /Баянхонгор, Эрдэнэцогт сум/		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.05.08	1а/3658	1				1		2017.05.26	A/410	2017.06.05	2017.07.17 2017.08.09	75	375.0	373.5	1.5	18. "Сүлд-Уул" ХХК Сангийн яаманд гомдол гаргасаныг хянаж тус компаний гомдлыг үндэслэлгүй гэж үзэн ТШ-ийг хууль журмын дагуу үргэлжлүүлж, ХААТХуулийн 29.4 дэх заалтын дагуу ТШ-ийг 30 хоногоор сунгажээ.
9	X.1.1.2.2	Байгалийн түүхийн музейн барилгын дээвэр, халаалтын засвар /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.03.28	A/99			1		1		2017.04.20	A/312	2017.06.16	2017.04.27 2017.06.27	65	70.5	68.9	1.63	18. Сангийн Яаманд гомдол гарч дахин тендер зарласан.
10	X.1.1.2.3	Түүх угсаатны зүйн музейн барилгын дээвэр, халаалтын засвар /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.03.28	A/99	1				1		2017.04.20	A/313	2017.04.25	2017.06.06	46	169.7	149.4	20.35	
11	XVI.2.1-3.1	Эмнэлгийн их засвар /Баянхонгор, Гурванбулаг сум/		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.05.17	A/205	1				1		2017.05.26	A/409	2017.05.26	2017.07.04	39	90.0	88.7	1.30	
12	XVI.2.1-3.2	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар ажлын дутуу санхүүжилт /Баянхонгор аймаг, Галуут сум/		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.01.23	A/35	1					1	2017.06.05	A/430	2017.06.06	2017.07.19	44	130.5	128.0	2.52	
13	XVI.2.1-3.3	Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн эмнэлгийн дотоод засварын ажил		1	Баянхонгор аймгийн ЭМГ-ын дарга А.Ганболд	2017.11.14	A/428			1		1		2017.11.29	A/811	2017.11.29	2017.12.06	7	78.0	71.7	6.32	

A	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23
14	XVI.3.2-3.1	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж, төсөл арга хэмжээний мотоцикл 6 ширхэг		1	Баянхонгор аймгийн ЭМГ-ын дарга А.Ганболд	2017.11.20	A/452			1		1		2017.11.29	A/810	2017.11.30	2017.12.11	13	10.8	10.68	0.12	
15	XVII.1.1	Баянхонгор сумын 4.5 дугаар багийн хүчдэлийн уналттай болон шинэ сууршлын бүсийн цахилгаан хангамж /Баянхонгор/		1	Баянхонгор аймгийн Засаг дарга	2017.09.07	120	1					1	2017.05.24	A/399	2017.06.07	2017.08.14	81	290.0	254.7	35.34	
		ДҮН		15				7	0	8	0	12	3	0	0	0	0	508	1722.4	1633.4211	88.979	

СУДАЛГАА ГАРГАСАН: АХЛАХ АУДИТОР

албан тушаал

*[Signature]*  
Б.ДОЛЖМАА

гарын үсэг

Гарын үсгийн тайлал

АУДИТОР

албан тушаал

*[Signature]*  
Б.АЗБАЯР

гарын үсэг

Гарын үсгийн тайлал

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

албан тушаал

*[Signature]*  
Д.ЦЭЦЭГМАА

гарын үсэг

Гарын үсгийн тайлал

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

албан тушаал

*[Signature]*  
Б.МӨНХБАТ

гарын үсэг

Гарын үсгийн тайлал



ХӨРӨНГӨ ОРОУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, САНХҮҮЖИЛТИЙН СУДАЛГАА

(сая төгрөг)

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Төсвийн түзэм хуулиар				Гүйцэтгэгч		Гэрээний				Гэрээнд оруулсан		Санхүүжүүлсэн дүн		Ахлын гүйцэтгэл		Хэрэгжээж дууссан				Хэрэгжилт дутуу шалтгаан				Хэрэгжээгүй шалтгаан		Гэрээ, санхүүжилт, харьцангуйн талаарх тайлбар				
			Хэрэгжээж		Төсөвт өртөг	Санхүүжээх дүн	Нэр	Рагастайрны дугаар	Байгуулсан		Ажил гүйцэтгэж дуусгав		Гэрээний нийт дүн	Сунгалт зийлсэн гэрээ дуусах өгнөө	Нийт ажил хэргэлсэн хойш	Үүнээс, 2017 онд	Нийт мөнгөн дунгаар	Үүнээс, 2017 онд	Улсын комисс хуулан авсан		Хэрэгжээж дууссан боловч улсын		Хүлээн авсан хуулиар	Хүлээн авсан хуулиар	Хүлээн авсан хуулиар	Хүлээн авсан хуулиар	Хүлээн авсан хуулиар	Хүлээн авсан хуулиар		Хүлээн авсан хуулиар	Хүлээн авсан хуулиар	Хүлээн авсан хуулиар	
			Эзлэх	Дуусах					Огноо	Гэрээний үнэ	Эзлэх	Дуусах							Огноо	Гэрээний үнэ	Эзлэх	Дуусах											Алтын дугаар
4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35		
1	IV.3.1.1	Эрдэнэцогт сумын ЗДТГазарт автомашин	2017	2017	35.0	35.0	"Хаш говь" ХХК	2133709	2017.12.15	50.0	2017.12.15	2017.12.20	0	0	35.0	35.0	35.0	35.0	Дугаар байгуул	2017.12.18	-	0											11. Орон нутгийн төсөөс 15.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн. Танилцуулга тусад нь бэлтгэж хүргүүлэв.
2	IV.3.1.3	Шинэжинст сумын ЗДТГазарт автомашин	2017	2017	35.0	35.0	"Өгөөмөр орд" ХХК	2668343	2017.12.15	50.0	2017.12.15	2017.12.20	0	0	35.0	35.0	35.0	35.0	Дугаар байгуул	2017.12.18	-	0											11. Орон нутгийн төсөөс 15.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн. Танилцуулга тусад нь бэлтгэж хүргүүлэв.
3	IV.3.1.2	Богд сумын ЗДТГазарт автомашин	2017	2017	35.0	35.0	"Баянхонгор Төмөрт" ХХК	3131327	2017.12.13	50.0	2017.12.13	2017.12.18	0	0	35.0	35.0	35.0	35.0	Дугаар байгуул	2017.12.18	-	0											11. Орон нутгийн төсөөс 15.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн. Танилцуулга тусад нь бэлтгэж хүргүүлэв.
4	XII.1.2.1.14	Собьын төвийн барилга /Баянхонгор, Баянговь сум/	2014	2017	1,157.0	186.9	"Эй Ар Би Си" ХХК	5100232	2014.06.12	938.6	2014.06.16	2014.12.15	1157.0	2017.12.13	1,157.0	186.9	1,157.0	186.9	№ 2017/30	2017.12.01	0	0											2017 оны 12 сард нэмэлт гэрээ байгуулсан. Дулаан оронгуут ажлыг хийж дуусгана. Танилцуулга тусад нь бэлтгэж хүргүүлэв.
5	XII.1.2.1.1.6	Сургуулийн барилгын засвар /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	2017	2017	140.0	140.0	"Базар дарь" ХХК	3123103	2017.06.23	138.4	2017.06.27	2017.08.20	0	0	138.4	138.4	138.4	138.4	№ 03	2017.06.26	0	6											Танилцуулга тусад нь бэлтгэж хүргүүлэв.
6	XII.1.2.1.1.7.6	Сургуулийн халаалтын засвар/Баянхонгор, Галуут сум/	2017	2017	50.8	50.8	"Базар дарь" ХХК	3123103	2017.06.15	50.8	2017.06.20	2017.08.10	0	0	50.8	50.8	50.80	50.8	№ 01	2017.07.18	0	0											17. БСШУСЯ-наас илгээлтийн ажлын 0.9 сая төгрөгийг суутан тооцож, аймгийн Төрийн сангийн дансаар 49.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Танилцуулга тусад нь бэлтгэж хүргүүлэв.
7	XII.1.2.1.1.7.5	Сургуулийн дотуур байрны гадна дулаан, халаалтын шугам /Баянхонгор, Өлзийт сум/	2017	2017	79.6	79.6	"RMB" ХХК	2551276	2017.06.23	69.0	2017.06.23	2017.08.21	0	0	69.0	69.0	69.0	69	№ 2017/11	2017.09.01	0	11											Танилцуулга тусад нь бэлтгэж хүргүүлэв.
8	XII.1.2.1.1.6	Сургуулийн барилгын дээвэр, гадна фасад засвар /Баянхонгор, Баян-Өндөр сум/	2017	2017	87.5	87.5	"Хорого групп" ХХК	5342597	2017.06.30	79.8	2017.07.01	2017.08.10	0	0	79.8	79.8	79.8	79.8	№ 2017/09	2017.09.04	0	25											Танилцуулга тусад нь бэлтгэж хүргүүлэв.
9	X.2.2.1.3	Хачин ламын сүмийг сэргээн засварлах ажил /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	2017	2017	375.0	375.0	"Жамьян-пайтан" ХХК	5044413	2017.08.21	373.5	2017.08.21	2017.12.15	0	0	373.5	373.5	373.5	373.5	№ 2017/21	2017.12.01	0	0											Танилцуулга тусад нь бэлтгэж хүргүүлэв.
10	X.1.1.2.2	Байгалийн түүхийн музейн барилгын дээвэр, халаалтын засвар /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/	2017	2017	68.9	68.9	"Эх Бүрдэн" ХХК	2605325	2017.07.05	68.9	2017.07.05	2017.07.20	0	0	68.9	68.9	68.9	68.9	№ 2017/02	2017.08.15	0	25											Танилцуулга тусад нь бэлтгэж хүргүүлэв.
11	X.1.1.2.3	Түүх угсаатны зүйн музейн барилгын дээвэр, халаалтын засвар /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/	2017	2017	149.4	149.4	"RMB" ХХК	2551276	2017.06.16	149.4	2017.06.20	2017.08.05	0	0	149.4	149.4	149.4	149.4	№ 2017/23	2017.08.29	0	14											Танилцуулга тусад нь бэлтгэж хүргүүлэв.
12	XVI.1.1.1	Сумын эрүү мандчин төвийн барилга 10 ор /Баянхонгор, Шаргалжуут сум/	2014	2017	1,112.7	300.0	"Алтайн газрын хүү" ХХК	4067622	2015.01.16	1,112.7	2015.05.30	2015.12.30	1,112.7	2017.09.30	1,112.7	300	1,112.7	300	№ БУ 43-959	2017.10.04	0	5											Танилцуулга тусад нь бэлтгэж хүргүүлэв.

